

Сvvлийн жилvvдэд тус хvрээлэнгийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа мэдэгдэхvйц оссон. Тухайлбал, АНУ-ын Калифорнийн Монтерей дэх Тэнгисийн цэргийн сургуулийн дэргэдэх Иргэн-цэргийн харилцааны тов, Швейцарь улсын Женев дэх Зэвсэгт хvчинд ардчилсан хяналт тавих тов, ОХУ-ын цэргийн шинжлэх ухааны хvрээлэн, Дорно дахины хvрээлэн, БХЯ-ны цэргийн тvvхийн институц, БНХАУ-ын Харбины Нийгмийн шинжлэх ухааны хvрээлэн, Номунхан судлалын тов, БНСУ-ын Батлан хамгаалах яамны Батлан хамгаалахын дvн шинжилгээний хvрээлэн, 731 дvгээр отрядыг судлах тов зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Энэхvv хамтын ажиллагааны хvрээнд АНУ-ын Калифорнийн Монтерей дэх Тэнгисийн цэргийн сургуулийн дэргэдэх Иргэн-цэргийн харилцааны тов, БНСУ-ын Батлан хамгаалах яамны Батлан хамгаалахын дvн шинжилгээний хvрээлэнтэй ажиллах санамж бичгийн хvрээнд хамтарсан сургалт семинар зохион байгуулах, хамтарсан ном бvтээл туурвих, судалгаа явуулах, бvтээл солилцох зэргээр ажиллаж байна.